

МОНГОЛЫН АРД ТҮМЭН ЯАГААД ЭНЭ ХҮНИЙГ МАРТДАГГҮЙ ВЭ?

Яо Кэ Чэн*

2006 оны 3 дугаар сарын 23

Пүрэв гарагийн өглөө

Өглөө эрт зурагт радиогоор цаг агаарын урьдчилсан мэдээг танилцуулж, Улаанбаатар хотод өдөр 6 хэмийн дулаан, шөнөдөө хасах 11 хэмийн хүйтэн байна хэмээн зарлав.

Хэдэн өдрийн өмнө Монгол Улсын Их сургуулийн Хятад хэл судлалын тэнхимийн багш Ц.Базаррагчаатай ярилцах зуураа, өнөө өглөө 10 цагаас МУИС-ийн 1 дүгээр байрын хурлын танхимд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт яруу найрагч Ж.Бадраа агсаны мэндэлсний 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болохыг мэдэж авсан билээ. Би Базаррагчаа багшаас урилгыг авч үзвэл, илтгэл тавих хүмүүсийн нэрсийн дунд миний танил хэд хэдэн зохиолч, багш байсан бөгөөд тэдэнтэй уулзахаар эртлэн босч, хувцаслаад ес хагаст хурлын танхимд ирэв. Хурлын тэргүүлэгчдийн индрээс зайдуухан нам гүм газарт сандал олж, Г.Цэрэнханд профессорын бичсэн "Монголчууд: угсаа-соёл, зан заншил" номын нэгдүгээр дэвтрийг уншихаар суулаа. Учир нь үдээс хойш Цэрэнханд багш зөвхөн надад зориулж энэ хичээлийг орох ёстой байсан юм.

Арван цаг арай болоогүй байхад эрдэм шинжилгээний хуралдоролцох хүмүүс эртлэн

ирж хурлын танхимыг дүүргэжээ. Тэдний дунд эрдэмтэн, урлаг соёлын салбараас нэрд гарсан миний таньж мэдэх алдартай хүмүүс байв. Базаррагчаа багш намайг хармагцаа дуудахад би дэргэд нь очиж суув. Тайваний шүлэгч Ши Мөрөн Бадраа гуайн ойд зориулж бичсэн шүлгийг Базаррагчаа багш дөнгөж сая орчуулж дууссанаа үзүүлэхийн сацуу хуралд оролцож буй алдар суутай зарим хүмүүсийг надад нам дуугаар танилцууллаа.

Арван цаг боллоо, Монголын нэрт хөгжмийн зохиолч, Монгол-Хятадын найрамдал нийгэмлэгийн тэргүүн Н.Жанцанноров хурлын үйл ажиллагааг нээж, хурлын тэргүүлэгчдийн ширээнд сууж буй хурлыг зохион байгуулагч гурван хүнийг танилцуулав. Үүнд: Монгол Улсын ШУА-ийн Хэл, зсхиоллын хүрээлэнгийн доктор, профессор Л.Хүрэлбаатар, Монгол Улсын Соёл урлагийн их сургуулийн захирал, нэрт зохиолч, профессор Д.Цэдэв болон Монгол Улсын Их сургуулийн Монгол хэл, соёлын сургуулийн захирал, профессор Бадамдорж нар байсан бөгөөд төдөлгүй үндсэн хуралдаан эхлэв. Үндсэн илтгэгчдийн дунд миний танил дөрвөн хүн байсныг тус тусад нь танилцуулбал, доктор, профессор Л.Хүрэлбаатар, Монгол Улсын ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн захирал,

*Яо Кэ Чэн - Бээжин Их сургуулийн Монгол судлалын төвийн багш, профессор

академич Н.Сампилдэндэв, МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн профессор Сүхбаатар болон Монголын Соёлын сангийн тэргүүн Г.Мэнд-Оёо гуай нар байлаа. Энэ хүмүүс бүгд Монгол Улсдаа өөр өөрийн гэсэн гавьяа шагнал, алдар нэртэй үүнээс Ж.Бадраа гуай Монголын ард түмний дунд үргэлжид сайнаар дурсагдах, асар их нэр хүндтэй хүн юм гэдгийг би харж суув.

Миний бие урьд өмнө Монголын хөгжмийн тухайд тусгайлан суралцаж, судлаагүй байсан учраас Ж.Бадраа гуайн амьдрал, уран бүтээлийн талаар өчүүхэн төдий мэдэж байсан. Хурлын төлөөлөгчдийн илтгэл, дурсамж, ярианаас, ялангуяа Базаррагчаа багшийн танилцуулснаар би Ж.Бадраа гуайн тухай бага сага мэдлэгтэй болж, улмаар Монголын ард түмэн Ж.Бадраа гуайг яагаад мартдаггүй вэ гэдгийг бүрэн ойлгож авсан юм. Учир нь Бадраа гуайн уран бүтээл зөвхөн урлагийн үнэ цэнээрээ цолхорсон бус эх орон, төрөлх нутгаа чин халуун сэтгэлээсээ хайрладаг хүн байсныг бүрэн дүүрэн мэдэж авлаа.

Ж.Бадраа гуай шүлгийг нь бичсэн "Халуун элгэн нутаг минь", аяыг Монгол Улсын ардын жүжигчин, төрийн шагналт хөгжмийн зохиолч Ц.Намсрайжав нарын зохиосон энэ дуу өргөн дэлгэр түгэн тархаж, Монгол Улсын хүн бүрийн дуулдаг дуу болон үеийн үед дуулагдсаар өдгөө хүрч Монгол Улсын төрийн дуулал /ардын дуулал-орч./ болжээ. Мөн Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны баруун талд тусгайлан зассан талбайд энэхүү дууны шүлэг, аяыг маш сүрлэг чулуун дээр сийлж, хөшөө болгон сүндэрлүүлжээ. Энэ дууны хөшөө бол Монгол Улсын түүхэнд урьд өмнө байгаагүй, дуунд зориулсан

анхны хөшөө ажээ. Өөрийн эх орон, ард түмнээ чин сэтгэлээсээ хайрладаг хүнийг улс орон ард түмэн үүрд дурсан санаж, мартдаггүй юм байна гэдгийг өнөөдрийн эрдэм шинжилгээний хуралд оролцож байж би гүн гүнзгий мэдэрлээ.

Үдээс хойш хичээлтэй тул 12 цагийн үед хурлын танхимыг би орхин гарлаа. Хичээлийнхээ дараа Гадаад Харилцааны Яамны баруун талд байрлах Ж.Бадраагийн шүлэг, Ц.Намсрайжавын шүлэг "Халуун элгэн нутаг минь" дууны хөшөөнд дахин очиж, Ж.Бадраа гуайн эх нутгаа, эх орноо зүрх сэтгэлээсээ хайрлаж бичсэн утга яруу уянгын шүлгийн бадгийг нягтлан ажиглалаа. Энэ үед дууны ая, үгийн дор том үсгээр "ХХ зууны манлай дуу" гэж бичсэнийг би сая л олж харлаа. Монголын ард түмэн Ж.Бадраа гуайг яагаад мартдаггүй вэ гэсэн асуултын хариулт улам бүр тодорхой болов.

Яо Кэ Чэн багш "Халуун элгэн нутаг минь" дууны шүлгийг хятад хэлээр орчуулсныг хавсаргав.

Ж.Бадраагийн шүлэг

ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ МИНЬ

Элэг зүрхнээс уяатай

Энхрий монгол нутаг минь

Эцэг эхээс заяатай

Эрдэнийн алтан өлгий еэ.

Цэцгийн шимийг тэтгэсэн

Цэнгэлийн хавар айлчлахаар

Мөрөн гол дуугаа дуулж

Мөнгөн сарьдаг нь мишээдэг ээ.

Сэвүүн салхиа сэвсүүлэн

Хацар нүүрийг үнсэн байж

Сэтгэл дотрыг ариулсан

Халуун элгэн нутаг минь

他为什么让蒙古人民如此怀念？

北京大学蒙古学研究中心 姚克成

2006年3月23日 星期四 晴

早晨电视台播出的天气预报说：乌兰巴托，晴，白天气温6度，夜间气温零下11度。

根据几天前与国立大学汉语教研室巴扎尔拉格查（Ц.Базаррагчаа）老师聊天时得知的信息，今天上午10时将在国立大学一号楼圆形会议厅举办纪念蒙古国功勋文化工作者、著名词作者、已故J·巴达拉（Ж.Бадраа）先生诞辰80周年学术研讨会。因为我从巴扎尔拉格查老师的邀请上公布的发言者名单中发现有好几位我认识的学者和老师，想趁机和他们见一面，所以老早换好了衣服，九时半就来到了会场，找了一个离主席台较远的座位坐了下来，静静地阅读策仁韩德教授编写的一本名为《蒙古人：民族、文化与风俗》（第一册）（Г.Цэрэнхандын зохиосон 《МОНГОЛЧУУД: УГСАА – СОЁЛ, ЗАН ЗАНШИЛ I》）的书，因为下午还要上策仁韩德教授为我单开的这门课。

快到十点钟了，前来参加研讨会的人们几乎坐满了整个会场。其中有好几位我认识的著名学者和文化艺术界的名人。巴扎尔拉格查老师看见我以后，把我叫到了身边，让我坐到他旁边的座位上。巴老师一边给我看他新近翻译的台湾诗人席慕蓉今年3月3日写的一首纪念J·巴达拉先生的诗，一边向我小声地介绍着一些与会的名人。

十点钟到了，蒙古著名作曲家、蒙中友协主席姜参诺日布（Жанцанноров）先生宣布会议开始，先介绍了坐在主席台上的其他三位会议组织者，他们是：蒙古科学院语言文学所的L·呼日勒巴特尔（Л.Хүрэлбаатар）教授、蒙古文化艺术大学校长著名作家D·策德布（Д.Цэдэв）教授和蒙古国立大学蒙古语言文化学院院长巴德玛道尔吉教授，然后开始了大会主题发言。在主题发言的人物中，我认识的人有四位，他们分别是：L·呼日勒巴特尔教授、蒙古科学院语言文学所所长H·散丕勒敦德布院士、蒙古国立大学蒙古语言文化学院策·苏赫巴特尔教授和蒙古文化基金会主席门德奥耀（Мэнд-Оёо）先生，这几位先生都是不同名称的蒙古国家级奖励的获得者，可见J·巴达拉先生在蒙古人民中的口碑之好、威望之高。

我因为没有进行过蒙古音乐的专门学习和研究，所以对 J·巴达拉先生的作品和生平所知甚少。通过与会代表的发言特别是经过巴扎尔拉格查老师的介绍，使我不仅对 J·巴达拉先生有了一点肤浅的了解，而且理解了 J·巴达拉先生为什么让蒙古人民如此怀念。这是因为：J·巴达拉先生的作品不仅艺术价值极高，而且充满了对家乡和祖国火一般的挚爱！

J·巴达拉先生的一首诗“我挚爱的祖国”（Халуун элгэн нутаг минь）被蒙古国人民演员国家奖获得者策·纳姆斯莱扎布（Ц.Намсрайжав）谱曲以后，变成了蒙古国人人都会唱的歌曲，其流行和普及的程度甚至超过了蒙古国国歌。这首歌曲还被刻到了一块很大的石碑上，立在了蒙古国外交部西边的一块专门开辟的场地上。这在蒙古国也是史无前例的。只有一个挚爱自己祖国和人民的人，才会得到该国人民的永久怀念。这就是我今天参加这场研讨会的最深感受。

因为下午有课，我在十二时左右不得不离开会场。下午下课以后，我再次专门来到了外交部西边那块刻有 J·巴达拉先生作词、策·纳姆斯莱扎布谱曲的“我挚爱的祖国”歌曲石碑旁，瞻仰了这块抒发 J·巴达拉先生爱国情怀的歌曲石碑。我这时才看到，在这首歌曲的下方还有一行醒目的大字——“二十世纪的最流行歌曲”（XX зууны манлай дуу）。蒙古人民如此怀念 J·巴达拉先生的答案，在此写得一清二楚。

附：J·巴达拉先生诗“我挚爱的祖国”

ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ МИНЬ

Элэг зүрхнээс уяатай

Энхрийн монгол нутаг минь

Эцэг эхээс заяатай

Эрдэнийн алтан өлгий еэ.

Цэцгийн шимийг тэтгэсэн

Цэнгэлийн хавар айлчлахаар

Мөрөн гол дуугаа дуулж

Мөнгөн сарьдаг нь мишээдэг ээ.

Сэвүүн салхиа сэвсүүлэн

Хацар нүүрийг үнсэн байж
Сэтгэл дотрыг ариулсан
Халуун элгэн нутаг минь.

我挚爱的祖国

(蒙古) J·巴达拉诗, 姚克成译

那是我魂牵梦绕的地方,
那是我爱之如痴的蒙古,
那是父母抚育我的摇篮,
我在那摇篮里茁壮成长。

那是花草如茵的地方,
每当大地回春的时候,
银色的雪山向我们微笑,
清澈的江河愉快地歌唱。

温暖的春风轻轻地吹来,
就像母亲吻着我的脸颊。
若问是谁净化了的我心灵,
她就是我最挚爱的祖国。

3

Жич: Яо Кэ Чэн багш намайг энэ өгүүллийг орчуулж нийтлүүлээрэй гэж өгсөн юм. Гэвч орчуулж амжилгүй өдгөө хүрсэнд багшаасаа хүлцэл өчиж байна. Энэ онд Ж.Бадраа агсаны мэндэлсний 85 жилийн ой тохиож байгаа учраас уг өгүүллийн агуулгын утга чанар хэвээр хэмээн бодож чадан ядан орчуулав.

Хятад хэлээс орчуулсан Ч.Батцэцэг